



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК
2022 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН**

КОМПАНИЙН ТУХАЙ

Монголын цахилгаан холбоо ХК нь 1921 онд “Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороо” нэрээр эмхлэгдэн байгуулагдсан, 102 жилийн түүхтэй, Монгол Улсын харилцаа холбооны салбарын ууган компани юм.

Компани нь 1992 онд “Монголын Харилцаа Холбоо” (МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО) компани, 1995 онд “Монголын Цахилгаан Холбоо” хувьцаат компани болон байгуулагдаж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж байсан, Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани юм.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 54.67 хувийг Монгол улсын Засгийн газар, 40.0 хувийг БНСУ-ын Кореа Телеком корпораци, 5.33 хувийг Монгол улсын болон гадаадын иргэд, хуулийн этгээд тус тус 1995 оноос 2018 оны хооронд эзэмшиж байсан.

Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Кореа телеком корпораци хооронд 2018 оны 4 сарын 19-ний өдөр байгуулсан гэрээний дагуу компанийн нийт хувьцааны 40 хувь буюу 10,348,111 ширхэг хувьцааг худалдах арилжаагаар Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьцааны хяналтын багцыг дангаараа худалдан авсан тул МУЗГ нь Компанийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн хувиас бусад хэсгийг худалдан авах тендерийн санал гаргаж, 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр нийт 7,572 ширхэг хувьцааг худалдан авсан.

Ийнхүү Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 94.7 хувь буюу 24,499,287 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.

Монголын цахилгаан холбоо ХК нь эрх бүхий байгууллагаас олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд Монгол улсын нийт нутаг дэвсгэрт улс, хот хоорондын цахилгаан холбоо, интернэт, кабелийн телевиз, лавлах үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж ажилладаг.

Монголын цахилгаан холбоо ХК нь Улаанбаатар хотын бүх дүүрэг, 21 аймаг, 290 гаруй сум сууринд үйлчилгээгээ хүргэн ажиллаж байгаа бөгөөд нийт 690 ажилтан, албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Алсын хараа

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн өргөн сонголт бүхий үйлчилгээ үзүүлэгч, өрсөлдөх чадвараар салбартаа тэргүүлэгч компани байна.

Эрхэм зорилго

Харилцаа бүрийг холбоно.

Үнэт зүйлс

ХЭРЭГЛЭГЧИЙН ДЭЭДЛЭЛ:

- Бид хэрэглэгч бүрийг зочин мэт дээдэлнэ.
- Бидний бүх ажил ямагт хэрэглэгчийн төлөө байна.
- Бид хэрэглэгчээ танин мэдэж, хэрэгцээ шаардлагад нь өөриймсөг хандана.

ХАМТ ОЛОН:

- Бид бэрхшээл саадыг хамтдаа туулж, амжилт ялалтыг багаараа бүтээнэ.
- Бид өргөн мэдлэг, өөдрөг үзэл, бүтээлч хандлагыг эрхэмлэнэ.

- Бид зорилго, итгэл, урам зоригтойгоор ирээдүйг төлөвлөн бүтээнэ.

ХАРИУЦЛАГА:

- Бид ажилдаа эзэн байж, хариуцлагаа ухамсарладаг зарчимч байна.
- Бид хариуцлагатай байдлыг бусдын итгэлийг даах үндэс гэж үзнэ.
- Бид бүх нийтийн үйлчилгээний үүрэг хариуцлагаа эрхэмлэнэ.

БРЭНД НЭР:

- Бид “Монголын цахилгаан холбоо” хэмээх эрхэм алдрыг үргэлж дээдэлнэ.
- Бид компанийнхаа нэр төрийн илэрхийлэл гэдгээ үргэлж санана.
- Бид хэрэглэгч, харилцагч, хамтрагчдадаа компаниа үргэлж эергээр ойлгуулна.

Уриа үг


“Холбоо хөгжлийн төлөө хамтдаа”

Бүтэц зохион байгуулалт


Монголын цахилгаан холбоо ХК нь 2022 онд Улаанбаатар хотын 4 бүсийн холбооны газар, Багануур, Налайх дүүргийн холбооны газар, 21 аймгийн холбооны газар, төв оффисын 6 газар, 11 албаны бүтэцтэйгээр үйл ажиллагааг явуулж байна.

МЦХ ХК-ийн ТУЗ-ийн 179 дүгээр хурлын № 01 тогтоолын Хавсралт.

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН БҮТЭЦ




ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ



Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 94.7 хувь буюу 24,499,286 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00-13:40 цагт цахим хэлбэрээр зохион байгуулагдлаа. 2022 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөр тасалбар болгон бүртгэсэн 25,870,276.0 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4,008 хувьцаа эзэмшигчдээс 24,505,887 ширхэг саналын эрх бүхий 13 хувьцаа эзэмшигч оролцож ирц 94.73 хувьтай байлаа. Хурлын даргаар МЦХ ХК-ийн Маркетинг борлуулалтын газрын захирал Содномдовжидын Нямбаяр, хурал зохион байгуулах комиссын даргаар Удирдлага хүний нөөцийн газрын захирал Ч.Цогтгэрэл, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа, Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер Ж.Азбаяр нар тус тус ажиллаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлууд

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;

2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
4. 2020 оны ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай;
7. Үл хөдлөх хөрөнгө данснаас хасах, шинээр олж авах тухай

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүд

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар баталж, Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрөв.
3. ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгов. Үүнд, А.Молорыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр, Ц.Норовжамц, Ж.Тамир, Ю.Бат-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр тус тус сонгов.
4. ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
5. Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хувьцаа эзэмшигчдийн хурлын эзгүйд компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан явуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байдаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэг (1/3) хараат бус гишүүн бөгөөд ердийн 6 гишүүн нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлдэг. 2022 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр ТУЗ-ийн дарга Т.Лхагвасүрэн, Г.Эрдэнэбулган, Ж.Цогтбаяр, Ч.Цэвэгдорж, М.Лхагважав, А.Молор, хараат бус гишүүн Ж.Тамир, Ц.Норовжамц, Ю.Бат-Эрдэнэ нар ажиллаа.

Төлөөлөн удирдах зөвлөл нь гурван хороодтойгоор ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн Ц.Норовжамц, гишүүдээр ердийн гишүүн Ж.Цогтбаяр, хараат бус гишүүн Ю.Бат-Эрдэнэ нар;

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн дарга, ердийн гишүүн Т.Лхагвасүрэн, гишүүдээр хараат бус гишүүн Ж.Тамир, хараат бус гишүүн Ц.Норовжамц нар;

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны даргаар хараат бус гишүүн Ж.Тамир, гишүүдээр ердийн гишүүн М.Лхагважав, хараат бус гишүүн Ю.Бат-Эрдэнэ нар тус тус ажиллаа.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 онд 7 удаагийн хурлаар 17 асуудал хэлэлцэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 11 удаа хуралдаж, 27 асуудал хэлэлцэж шийдвэр гаргасан байна. Нийт 3 удаагийн хурлыг танхимаар хуралдаж, зайнаас 6 удаа, танхим болон зайнаас хосолсон байдлаар 2 удаа хуралджээ. Төлөөлөн удирдах зөвлөлөөс нийт 24 тогтоол, 4 тэмдэглэл гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо нэг удаа, Аудитын хороо 5 удаа, Нэр дэвшүүлэх хороо хоёр удаа тус тус хуралдаж санал, дүгнэлтээ боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсан байна. Аудитын хороо 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцууллаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын гүйцэтгэл

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 144.4 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 114 сая төгрөг буюу 79 хувийн гүйцэтгэлтэй, 29.7 сая төгрөг хэмнэсэн байна.

№	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн	Гүйцэтгэл	Хувь
1. Цалин, холбоо, тээврийн зардал							
1	ТУЗ-ийн гишүүний цалин	9	805,000	12	86,940,000	86,940,000	100%
2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	620,000	12	7,440,000	4,368,000	59%
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбооны зардал	1	150,000	12	1,800,000	1,800,000	100%
Цалин, холбоо, тээврийн зардлын дүн					96,180,000	93,108,000	97%
4	Нийгмийн даатгалын шимтгэл				12,984,300	9,635,850	74%
Дэд дүн					109,164,300	102,743,850	94%
2. Бичиг хэрэг, хурлын зардал							
1	Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал	1	150,000	12	1,800,000	804,119	45%
2	ТУЗ-ийн хэрэгцээнд зөөврийн компьютер, дуу хураагч авах, үзүүлэлт оруулах	1	5,000,000	1	5,000,000	4,900,000	98%
3	Хурал зохион байгуулах байрны түрээс	1	200,000	4	800,000	180,000	23%
4	Бусад зардал	1	110,000	6	660,000	-	0%
Дэд дүн					8,260,000	5,884,119	71%
3. ХХМТ-ийн салбар болон дэд бүтэц, бусад холбогдох салбарын туршлага судлах, хурал, үзэсгэлэнд оролцох, сургалтын зардал							
1	Тээврийн зардал	5	2,500,000	1	12,500,000	3,556,830	28%
2	Зам хоног /5 өдөр/	5	145,000	5	3,625,000	725,000	20%
3	Зочид буудал /5 өдөр/	5	435,000	5	10,875,000	1,775,000	16%
Дэд дүн					27,000,000	6,056,830	22%
Нийт дүн					144,424,300	114,684,799	79%

2022 ОНД НОГДОЛ АШИГ ТАРААСАН ТАЙЛАН

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн №1 тоот тогтоолын дагуу компанийн 2020 оны цэвэр ашгаас ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэж нэгж хувьцаанд 1 (нэг) төгрөг байхаар тогтоосон.

Ногдол ашиг шилжүүлсэн байдал

№	Хувьцаа эзэмшигчийн төрөл	Хувьцааны Тоо /ширхэг/	Ногдол ашгийн дүн /₮/	Татварын дараах шилжүүлсэн дүн /₮/	Тараасан хэлбэр
1	Төрийн өмч	24,499,287	24,499,287.0	24,499,287.0	Төрийн сан дахь ТӨБЗГ-ын дансанд
2	Монгол улсын иргэн, хуулийн этгээд - нийт 3,928 хувьцаа эзэмшигч	1,265,351	1,265,351.0	1,138,815.9	ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан хуваарилсан
3	Гадаадад амьдардаг иргэн, хуулийн этгээд - нийт 69 хувьцаа эзэмшигч	105,638	105,638	84,510.4	ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан хуваарилсан
	Татварт суутгасан дүн	-	-	147,662.7	
	НИЙТ ДҮН	25,870,276	25,870,276	25,870,276	

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

МЦХ ХК эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд Улаанбаатар хот болон орон нутагт улс, хот хоорондын цахилгаан холбоо, интернэт, олон суваг дамжуулах үйлчилгээ, мэдээллийн лавлах, телекамерын үйлчилгээг үзүүлж байна. Улаанбаатар хотын төв байранд 6 газар, 11 алба, 1 охин компани, 21 аймгийн төв болон 290 сумдад, нийт 690 ажилтан, албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2022 онд үндсэн үйл ажиллагааг өргөжүүлэхээр хийсэн онцлох ажлаас дурдвал:

1. Бизнесийн байгууллагуудад зориулсан **7070-XXXX** брэнд дугаарын зах зээлд нэвтрүүлсэн.
2. Сурагчдын эрсдэлээс сэргийлэх, гэр бүлийн гишүүдтэйгээ үнэгүй холбогдох, 10 хүртэлх насны сурагчдыг гараас гарт хүлээлгэж өгөх журмын заалтад дэмжлэг болох зорилготой хэрэгжүүлж буй **Итгэлтэй утас** таксофон үйлчилгээг хөгжүүлэн цэгийн тоог 105-д хүргээд байна.
3. "Барилгын хөгжлийн" төв-тэй хамтран "Телекамер" нэгдсэн систем нэвтрүүлээ.
4. Хамтын ажиллагааг хөгжүүлэхээр Батлан хамгаалах яамны Цэргийн анги, Монгол улсын ерөнхий прокурорын газар, Монголын төмөр зам, Аудитын ерөнхий газар, Соёлын яам зэрэг газруудад харилцаа холбооны үйлчилгээг хүргэсэн.
5. Эрүүл мэндийн яамтай **"Эмнэлгийн цаг олгох"** үйлчилгээг нэвтрүүлсэн.
6. **"ONDO"** ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан.

7. Нийгмийн хариуцлагын хүрээнд Цахим хөгжил харилцаа холбооны яамтай хамтран зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг дэмжин өргөжүүлэх ажлыг эхлүүлж амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур 1,501 өрхийг шилэн кабелийн интернэтийн үйлчилгээнд холбосон.
8. ХУРДАН төрийн үйлчилгээний цэгийг 4 холбооны газруудад нээж, цаашид компанийн бүх салбар нэгжээр дамжуулан төрийн цахим үйлчилгээг операторын горимоор үзүүлж эхлэхээр бэлтгэл хангаж байна.
9. 2022 онд 7 аймгийн 12 сумдад өндөр хурдны интернэт үйлчилгээг шилэн кабелиар хүргэх төслийн хүрээнд 53.3 км магистраль кабелийг агаарын баганат шугамаар суурилуулж цэгийн тоог 1303-аар нэмэгдүүллээ.
10. TV ROOM үйлчилгээний өргөтгөл шинэчлэлийг хийн нийт хэрэглэгчийг 2800 –д хүргэн ашиглалт үйлчилгээний зардлыг 5 дахин буулгаж, онлайн төлбөр тооцооны хялбар шийдэл нэвтрүүлэн, ТВ сувгийн нөөц системтэй болсон.
11. Баян-Өлгий аймгийн Ногооннуур сум, Цагааннуур тосгонд орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэгтэйгээр Тоон системийн кабелийн телевизийн үйлчилгээг нэвтрүүлэн хэрэглэгчийн тоог 300-р нэмсэн.
12. Компанийн цахим хуудсыг шинэчлэн онлайн төлбөр тооцооны хялбар шийдэл, картын онлайн борлуулалт, шинэ хэрэглэгчийн үйлчилгээний захиалга цахимаар хийх боломж бүрдсэн.
13. МТС Сервис ХХК нь харилцаа холбооны үйлчилгээний аутсорсинг, тоон гарын үсэг, UB Cab, 1900-1109 Үндэсний лавлах, Даатгал зуучлал, E-Mongolia, тоног төхөөрөмжийн борлуулалт, МТС Academy сургалтын үйлчилгээ үзүүлж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлан / аудитлагдсан /

мян.төгрөг


Үзүүлэлт	2021	2022
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	983,774	308,009
Авлага	2,748,282	3,876,568
Бусад санхүүгийн хөрөнгө	3,430,407	1,500,000
Бараа материал	2,701,204	3,216,554
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,703,704	472,470
Үндсэн хөрөнгө	22,204,401	26,224,751
Биет бус хөрөнгө	9,094,953	13,305,392
Бусад хөрөнгө	127,526	136,319
Нийт хөрөнгө	42,994,251	49,040,063

Богино хугацаат өр төлбөр	4,130,954	8,001,021
Урт хугацаат өр төлбөр	4,370,850	4,370,850
Нийт өр төлбөр	8,501,804	12,371,871
Эздийн өмч	2,587,028	2,587,028
Эздийн өмчийн бусад хэсэг	9,246,757	13,494,825
Хуримтлагдсан ашиг	22,658,663	20,586,340
Нийт эздийн өмч	34,492,447	36,668,192
Нийт өр төлбөр болон эздийн өмч	42,994,251	49,040,063

Үзүүлэлт	2021	2022
Борлуулалтын орлого /цэвэр/	17,990,130	18,814,060
Борлуулалтын өртөг	(13,523,395)	(14,629,977)
Үйл ажиллагааны ашиг/(алдагдал)	4,466,735	4,184,082
Борлуулалт, маркетингийн зардал	(1,256,557)	(1,153,577)
Ерөнхий ба удирдлагын зардал	(2,544,492)	(2,338,350)
Бусад зардал	(626,564)	(658,040)
Нийт зардал	(4,427,613)	(4,149,968)
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	39,122	34,114
Татварын зардал	(34,407)	(23,414)
Цэвэр ашиг	4,715	10,700

Хөрөнгийн зах зээл ба компанийн хувьцааны үзүүлэлт

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2022.12.31-ний өдрийн хаалтын ханшаар 17,048,511,884 төгрөг байна. 2022 оны арилжааны мэдээллийг графикаар үзүүлэв.



2022 оны хувьцааны арилжааны тухай мэдээлэл

ҮЗҮҮЛЭЛТ	2022 он	2021 он	2020 он	Өсөлт, бууралт	
				2022/2021	2021/2020
Хувьцааны ханш / төгрөг /					
Хаалтын ханш	659.00	712.05	347.54	-7%	105%
Хамгийн өндөр ханш	725.38	800.00	472.00	-9%	69%
Хамгийн бага ханш	450.00	379.92	307.29	18%	24%
Дундаж ханш	614.50	609.09	392.15	1%	55%
Арилжигдсан тоо / ширхэг /					
Хамгийн их /өдөрт /	1,020	20,074	1,850	-95%	985%
Хамгийн бага /өдөрт /	1	1	1	0%	0%
Дундаж /өдөрт/	189	533	254	-65%	110%
Нийт	12,466	77,320	16,557	-84%	367%

Арилжааны үнийн дүн / төгрөг /					
Хамгийн их /өдөрт /	612,000	12,044,601	741,850	-95%	1524%
Хамгийн бага /өдөрт /	590	649	402	-9%	61%
Дундаж /өдөрт/	113,143	320,928	96,905	-65%	231%
Нийт	7,467,446	46,534,525	6,298,820	-84%	639%
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төгрөг/	17,048,511,884	18,420,930,026	8,990,955,721	-7%	105%

2022 ОНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт хөрөнгө 49.0 тэрбум төгрөг
Нийт эздийн өмч 36.6 тэрбум төгрөг
Нийт орлого 18.8 тэрбум төгрөг
Цэвэр ашиг 10.7 сая төгрөг

Төсөвт төвлөрүүлсэн татвар хураамж

Үзүүлэлт / мянган төгрөг /	2021	2022
Төсвийн төлбөрт нийт дүн	3,303,800	2,533,821
а/Орлогын татвар	34,407	23,414
б/ НӨАТ	1,164,376	507,350
в/НДШ	1,661,550	1,562,035
г/Хүн амын орлогын татвар	409,518	391,782
д/Үл хөдлөхийн татвар	18,063	29,514
е/Гаалийн татвар	-	-
ж/Тээврийн хэрэгслийн татвар	4,736	4,445
и/Бусад татвар /Газрын төлбөр/	11,148	15,280

МЦХ ХК
2023 он